

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ**  
**/Шинэчилсэн найруулга/**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**  
**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж**

2.1. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын Олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэхтэй холбогдсон дараахь харилцааг зохицуулна:

3.1.1. Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаа;

3.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа болон агаарын зайд нислэг үйлдэж байгаа иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа;

3.1.3. Гадаад улсын хуульд өөрөөр заагаагүй бол тухайн улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа Монгол Улсын иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа.

3.3. Монгол Улсын хяналттай агаарын зайд нислэг үйлдэж байгаа улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгээс бусад нислэгийн хөдөлгөөнийг удирдахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.4. Монгол Улсын хяналттай агаарын зайд агаарын хөлгөөс бусад төхөөрөмжөөр нислэг үйлдэх харилцааг холбогдох хууль, дүрмээр зохицуулна.

**4 дүгээр зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд баримтлах зарчим**

4.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1. аюулгүй;

4.1.2. үр ашигтай;

4.1.3. хүртээмжтэй;

4.1.4. хараат бус.

**5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1. “агаарын зай” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрээс дээшхи хийн мандлын агаарын давхрагын орон зайг;

5.1.2. “агаарын навигацийн байгууламж” гэж агаарын навигацийн үйлчилгээнд ашиглагдах барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг;

5.1.3. “агаарын навигацийн үйлчилгээ” гэж Монгол Улсын нислэгийн хөдөлгөөний хяналттай агаарын зайд үйлдэгдэж буй нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний менежмент, холбоо, навигаци, ажиглалт, нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой

мэдээлэл дамжуулах, тэдгээрийн кибер аюулгүйн хамгаалалтыг багтаасан цогц үйл ажиллагаа;

5.1.4. “агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадах аливаа төхөөрөмжийг;

5.1.5. “аэродром” гэж агаарын хөлгийг байрлуулах, хөөргөх, буулгах, явгалахад зориулж тусгайлан тоногдсон газар болон усан гадаргууг;

5.1.6. “Иргэний нисэхийн дүрэм” гэж Олон улсын иргэний нисэхийн тухай “Чикагогийн конвенц” /цаашид “Конвенц” гэх/, түүний хавсралтууд Хавсралтын стандарт, зөвлөмжүүдийг хангах үүднээс энэ хуульд нийцүүлэн боловсруулж, эрх бүхий байгууллагаас баталсан, захиргааны ерөнхий хуульд заасан хэм хэмжээний актын шинжийг агуулсан, нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын зохицуулалтын баримт бичгийг;

5.1.7. “нислэгийн аюулгүй байдал” гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг;

5.1.8. “нисэхийн аюулгүй байдал” гэж агаарын хөлгийн ашиглалт буюу түүнд хамаарах дэмжлэг үзүүлэх аюулгүй үйл ажиллагаатай холбоотой эрсдлийг бууруулах, зөвшөөрөгдөх хэмжээнд хянах төлөв байдлыг;

5.1.9. “нислэг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор зогсоолоос хөдлөхөөс эхлэн хөөрөх, газарт бууж хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх үйл явцыг;

5.1.10. “осол” гэж нисгэгчтэй агаарын хөлөгт аливаа этгээд нислэг үйлдэх болон зорчих зорилгоор агаарын хөлгийн бүхээгт орсон үеэс эхлэн хөлгийн бүхээгийг орхих хүртэл, нисгэгчгүй агаарын хөлөгт нисэх зорилгоор хөдөлж эхлэхээс нислэг дуусах ба үндсэн хөдөлгүүрийг унтраах хүртэл хугацаанд болсон дараах тохиолдлыг:

а) агаарын хөлөгт байх үедээ эсхүл агаарын хөлөгтэй буюу агаарын хөлгөөс салсан хэсэгтэй шууд харьцсаны улмаас эсхүл хөдөлгүүрийн хийн урсгалын шууд нөлөөлөлд орсноос амь насаа алдах буюу хүнд гэмтэл авах;

Ердийн шалтгаанаар үүссэн гэмтэл, өөрийгөө гэмтээх буюу бусдаас гэмтэл авах, нисэх баг болон зорчигчид зориулагдаагүй агаарын хөлгийн хэсэгт нуугдаж байснаас авсан гэмтлүүд үүнд хамаарахгүй.

б) агаарын хөлөг гэмтэл авах буюу түүний их бие, бүтэц эвдрэлд орсны улмаас үндсэн хийцийн бөх бат чанар болон нислэг техникийн үзүүлэлтүүд ноцтой алдагдсан эсхүл том хэмжээний засвар хийх буюу гэмтсэн эд ангийг солих шаардлагатай болсон;

в) агаарын хөлөг сураггүй алга болох буюу эсхүл хүрэх боломжгүй газарт байх.

5.1.11. “зөрчил” гэж ослоос бусад агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдалд нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй нислэгийн хэвийн бус нөхцөл байдлыг;

5.1.12. “шинжлэн шалгах” гэж агаарын хөлгийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нөлөөлсөн хүчин зүйл бүрийг тогтоож, дүгнэлт гарган, аюулгүй байдлын зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

5.1.13. “Нисэхийн мэдээллийн эмхэтгэл” гэж тухайн улсаас эсхүл тухайн улсын зөвшөөрлөөр эрхлэн гаргадаг, агаарын навигацид чухал шаардлагатай, тогтмол шинж чанартай нисэхийн мэдээллийг агуулсан хэвлэлийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ**

### **6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1. Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

6.1.2. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

- 6.1.3. Иргэний нисэхийн асуудлаарх олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;
- 6.1.4. Хуульд заасан бусад бүрэн эрх.

### **7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

7.1. Засгийн газар иргэний нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 7.1.1. Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаарх төрийн бодлого, иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- 7.1.2. Хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар хоорондын агаарын харилцааны олон улсын гэрээ байгуулах;
- 7.1.3. Олон улсын гэрээ болон хууль тогтоомжид нийцүүлэн нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөр (журам) батлах;
- 7.1.4. Иргэний нисэхийн улсын хяналтын дүрмийг батлах;
- 7.1.5. Олон улсын нисэх буудал байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;
- 7.1.6. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг томилох, чөлөөлөх;
- 7.1.7. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох;
- 7.1.8. Хуульд заасан бусад бүрэн эрх.

### **8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

8.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 8.1.1. Иргэний нисэхийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;
- 8.1.2. Иргэний нисэхийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах;
- 8.1.3. Нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр (журам)-ийг Конвенцын Хавсралт 19-ийн дагуу батлах;
- 8.1.4. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах;
- 8.1.5. Иргэний нисэхийн дүрмийг батлах;
- 8.1.6. Иргэний нисэхийн аюулгүй байдлын стандартыг батлах;
- 8.1.7. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтын дүрмийг батлах;
- 8.1.8. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих;
- 8.1.9. Олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;
- 8.1.10. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах;
- 8.1.11. Аэродромыг ангилах, бүртгэх журмыг батлах;
- 8.1.12. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бүтцийг батлах;
- 8.1.13. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дарга бөгөөд ерөнхий шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;
- 8.1.14. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэд даргыг томилох, чөлөөлөх;
- 8.1.15. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг шаардлагатай гэж үзвэл гадаад улсын агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий холбогдох байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл тухайн байгууллагад хэсэгчлэн буюу бүрэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
- 8.1.16. Иргэний нисэхийн зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журмыг батлах;
- 8.1.17. Хуульд заасан бусад бүрэн эрх.

## **9 дүгээр зүйл. Төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг**

9.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

9.2. Төрийн захиргааны байгууллага дараах чиг үүрэгтэй байна:

9.2.1. Конвенц, түүний хавсралтуудад нийцсэн аюулгүй байдлын стандарт, дүрэм боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

9.2.2. Хэлэлцэн тохиролцогч улсын иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох;

9.2.3. Иргэний нисэхийн дүрэм болон Конвенцын стандартын зөрүүтэй байдлыг мэдээлэх;

9.2.4. Иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой өгөгдөл, мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, хадгалалт хамгаалалтыг хариуцах, түүнчлэн энэ асуудлаар бусад этгээдтэй хамтран ажиллах.

9.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хяналт, аюулгүй байдлын удирдлага, зохицуулалтын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжүүдтэй байх бөгөөд хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхитай байна.

## **10 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын дарга, түүний бүрэн эрх**

10.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга бөгөөд Улсын ерөнхий байцаагч /цаашид “Дарга” гэх/ иргэний нисэхийн мэргэжилтэй, дээд боловсролтой, тухайн салбартаа 15-аас доошгүй жил ажилласан, нисэхийн аюулгүйн хяналтын улсын байцаагчид тавих шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна.

10.2. Дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хариуцах;

10.2.2. Нисэхийн аюулгүйн хяналтын улсын байцаагчийг томилох, чөлөөлөх;

10.2.3. Иргэний нисэхийн дүрмийг ашиглах зөвлөмжийн цуврал, өргөдөл, хүсэлт гаргах маягт, бүртгэлийн дэвтэр, ерөнхий заавар, техник технологийн баримт бичгийг батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах;

10.2.4. Нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэл олгох;

10.2.5. Иргэний нисэхийн салбарын хэмжээнд олгогдох зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох, зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нөхцөл, шаардлагыг хангуулах зорилгоор зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

10.2.6. Аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн агаарын хөлгийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

10.2.7. Иргэний нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөх нөхцөл байдал шинээр үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай тушаал гаргаж, мэдээлэх;

10.2.8. Нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

10.2.9. Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй тохиолдолд нислэгийг зогсоох хүртэл арга хэмжээг авах;

10.2.10. Хууль болон албадан хэрэгжүүлэх дүрмийн дагуу хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох арга хэмжээ авах;

10.2.11. Зохицуулах үйлчилгээ, хяналт шалгалтын ажлын үнэлгээний хэмжээг тогтоох;

- 10.2.12. Аюулгүйн үзлэг, хамгаалалт шаардлагатай нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг батлах;
- 10.2.13. Энэ хуульд заасны дагуу Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх;
- 10.2.14. Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих.
- 10.2.15. Хуульд заасан бусад бүрэн эрх.

### **11 дүгээр зүйл. Эрх шилжүүлэх**

11.1. Дарга иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтад хамаарах энэ хуулийн 10.2.4, 10.2.5, 10.2.6, 10.2.8, 10.2.9, 10.2.10-д заасан бүрэн эрхээ нисэхийн хяналтын байцаагч болон нисэхийн ажилтнаар гүйцэтгүүлж болно.

11.2. Энэ зүйлийн 1-д заасан бүрэн эрхийг гүйцэтгэснээс үүсэх үр дагавар, хариуцлагыг дарга өөрөө хүлээнэ.

11.3. Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх журмыг Монгол Улсын Олон улсын гэрээ, хууль тогтоомжид нийцүүлэн Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн тогтооно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **12 дугаар зүйл. Иргэний нисэхийн зохицуулалт**

12.1. Иргэний нисэхийн зохицуулалт нь иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт; иргэний нисэхийн аюулгүй байдлын зохицуулалт; иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтаас бүрдэнэ.

### **13 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмийн зохицуулалт**

13.1. Иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалттай холбоотой үйл ажиллагааг энэ хуульд нийцүүлэн гаргасан дараах дүрмээр зохицуулна:

- 13.1.1. Иргэний нисэхийн дүрэм боловсруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлөх;
- 13.1.2. Осол, зөрчлийг мэдээлэх болон албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- 13.1.3. Агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийг гэрчилгээжүүлэх, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын удирдамж болон техник үйлчилгээ;
- 13.1.4. Нисэхийн мэргэшсэн ажилтны үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлт;
- 13.1.5. Агаарын зайг тогтоох, ангилах болон агаарын зайн зохицуулалт;
- 13.1.6. Нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм;
- 13.1.7. Хэрэглэлийн нислэг;
- 13.1.8. Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны нийтлэг зохицуулалт;
- 13.1.9. Хүнгүй агаарын хөлөг, аргамжаат шүхэр болон хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт;
- 13.1.10. Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр;
- 13.1.11. Агаарын хөлгөөр аюултай барааг тээвэрлэх болон зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 13.1.12. Том, дунд, жижиг агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон дотоод, гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт;
- 13.1.13. Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх, хөдөө аж ахуйн агаарын хөлөг болон чөлөөт нисэхийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт;
- 13.1.14. Аэродром байгуулах болон аэродромын үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт;
- 13.1.15. Аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 13.1.16. Нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 13.1.17. Агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон техник үйлчилгээ хийх байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 13.1.18. Шүхэр, хэт хөнгөн агаарын хөлөг болон нисэх клубийн гэрчилгээжүүлэлт;

13.1.19. Агаарын навигацийн техник үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, шалгалтын нислэг, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;  
13.1.20. Олон улсын гэрээ, Конвенцод орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу батлах болон шаардлагатай бусад дүрэм.

13.2. Энэ зүйлд заасан дүрмийг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу бүртгүүлнэ.

13.3. Иргэний нисэхийн дүрэм нь Конвенцын Хавсралтуудын дагуу боловсруулагдах бөгөөд тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулна.

#### **14 дугаар зүйл. Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлөх**

14.1. Тухайн дүрмээр хориглоогүй ба дараах нөхцөлийг зэрэг хангасан тохиолдолд дарга иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлж болно:

14.1.1. Хүсэлт гаргагч нь хүлээн зөвшөөрч болохуйц өөр хэлбэрээр дүрмийн шаардлагыг хангасан, эсхүл санал болгосон арга хэмжээ нь дүрмийн тухайн заалтыг хэрэгжүүлэхээс илүү үр дүнтэй;

14.1.2. Нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй болох нь тогтоогдсон;

14.2 Иргэний нисэхийн дүрмийн шаардлагаас чөлөөлсөн тухай шийдвэрийг нийтэд мэдээлнэ.

14.3 Дүрмийн шаардлагаас чөлөөлөхдөө энэ хуулийн 13.1.1-д заасан дүрмийг баримтална.

#### **15 дугаар зүйл. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зохицуулалт**

15.1. Иргэний нисэхийн чиглэлээр эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

15.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь зохицуулалтын дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.2.1. Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу иргэний нисэхийн салбарын хэмжээнд олгогдох зөвшөөрлийг иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

15.2.2. Агаарын тээвэрлэгч, иргэний нисэхийн үйлчилгээний байгууллага, нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэл, агаарын хөлгийн бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх.

#### **16 дугаар зүйл. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалт**

16.1. Иргэний нисэхийн эдийн засгийн дүрмээр дараах харилцааг зохицуулна:

16.1.1. Олон улсын хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох;

16.1.2. Агаарын навигаци, нисэх буудал, аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт болон иргэний нисэхийн бусад үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг хянан баталгаажуулах;

16.1.3. Зорчигч, тээш, ачаа тээвэрлэлтийн ерөнхий нөхцөл;

16.1.4. Агаарын тээвэрлэгчийн даатгал;

16.1.5. Иргэний нисэхийн статистикийн мэдээлэл цуглуулах, түгээх;

16.1.6. Агаарын навигаци, нисэх буудлын чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалт салбарын өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээнд нийцсэн, үр ашигтай байгаа эсэхэд хяналт тавих;

16.1.7. Агаарын навигаци, нисэх буудал болон агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хөрөнгө оруулалт, аюулгүй байдлыг хангах санхүүгийн чадавхид үнэлгээ хийх аргачлал;

16.1.8. Бусад.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### ***17 дугаар зүйл. Иргэний агаарын хөлөг***

17.1 Улсын нисэхийн тухай хуульд заасан улсын агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийг “иргэний агаарын хөлөг” гэнэ.

### ***18 дугаар зүйл. Агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэл***

18.1. Төрийн захиргааны байгууллага агаарын хөлгийн үндэсний харьяаллын болон улсын бүртгэлийн тогтолцоотой байна.

18.2. Иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа, бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсад бүртгүүлнэ.

18.3. Бүртгэлгүй агаарын хөлгөөр Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэхийг хориглоно.

18.4. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн тохиолдолд агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно.

18.5. Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ тухайн агаарын хөлгийн үндэсний харьяаллыг гэрчлэх ба агаарын хөлгийн өмчлөлийг нотлохгүй.

### ***19 Иргэний агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар***

19.1. Агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн нислэгийн аюулгүй байдалд тавигдах шаардлагыг хангаж байгааг “нислэгт тэнцэх чадвар” гэнэ.

19.2. Монгол Улсад хүлээн зөвшөөрсөн агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж болно.

19.3. Гадаад улсад үйлдвэрлэгдсэн агаарын хөлөг /маяг/-ийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд уг агаарын хөлгийг Монгол Улсад зорчигч тээврийн нислэг үйлдэх зорилгоор ашиглахыг зөвшөөрнө.

19.4. Маягийн гэрчилгээний шаардлага хангасан, үзлэг, шалгалтаар нислэгийн аюулгүй байдлыг хангах нөхцөлд байгаа агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.

19.5. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг оруулна.

19.6. Энэ зүйлтийн 19.4-т заасан “маягийн гэрчилгээ” гэдэгт агаарын хөлгийн хийц нислэгт тэнцэх чадварын холбогдох шаардлагад нийцэж байгааг Хэлэлцэн тохиролцогч улсын эрх бүхий байгууллагаас тодорхойлж олгосон баримт бичгийг ойлгоно.

## **20 дүгээр зүйл. Нислэгийн үйл ажиллагааны төрөл**

20.1. Нислэгийн үйл ажиллагаа нь арилжааны агаарын тээврийн болон ерөнхий зориулалтын нисэхийн төрөлтэй байна.

## **21 дугаар зүйл. Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа**

21.1. Арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа нь агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

21.1.1. 30-аас дээш зорчигчийн суудалтай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж 3410 килограммаас дээш том нисэх онгоцны;

21.1.2. 10-30 зорчигчийн суудалтай, эсхүл төлбөрт ачааллын багтаамж 3410 килограмм дунд нисэх онгоцны;

21.1.3. нисдэг тэрэг, эсхүл 9 ба түүнээс доош зорчигчийн суудалтай нисэх онгоцны.

## **22 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ**

22.1. “Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэж Агаарын хөлгөөр арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхэд олгож буй зөвшөөрлийг ойлгоно.

22.2. Томилогдсон гадаадын агаарын тээвэрлэгч энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан нөхцөлд түүнд гадаадын агаарын тээвэрлэгчийн Монгол Улсын гэрчилгээ олгож болно.

22.3. Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

## **23 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн үүрэг**

23.1. Иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийг “агаарын тээвэрлэгч” гэнэ.

23.2. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй агаарын тээвэрлэгч дараах үүрэгтэй:

23.2.1 нислэгийн үйл ажиллагааг олгогдсон гэрчилгээ болон түүний хавсралт үйл ажиллагааны тодорхойлолтод заасан эрх хязгаарлалт, гэрээний үүргийн хүрээнд гүйцэтгэх;

23.2.2. иргэний нисэхийн дүрмийн шаардлага хангасан удирдлага, зохион байгуулалтын бүтэцтэй байх;

23.2.3. үйл ажиллагаандаа тохирсон агаарын хөлөг болон шаардагдах тооны нислэгийн ажилтантай байх;

23.2.4. ашиглаж байгаа агаарын хөлөг болон түүний бүрдэл хэсгийн үзлэг, засвар үйлчилгээг гэрчилгээний эрх, хязгаарлалтын хүрээнд гүйцэтгэх;

23.2.5. агаарын хөлгийн осол, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх;

23.2.6. аюултай барааг иргэний нисэхийн дүрэм болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Техникийн зааварчилгааны дагуу тээвэрлэх;

23.2.7. нислэгийн үйл ажиллагааны болон агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын шаардлагад нийцсэн заавар, журам боловсруулж мөрдөх, холбогдох хууль тогтоомжийн дагуу нийтийн ашиг сонирхолд нийцсэн найдвартай үйлчилгээ үзүүлэх.

23.3. Агаарын тээвэрлэгч нь олон улсын нислэг үйлдэхдээ зорчигчийн мэдээллийг иргэний агаарын хөлөг хөөрөхөөс өмнө Монгол Улсын эрх бүхий байгууллагад урьдчилан хүргүүлнэ.

## **24 дүгээр зүйл. Агаарын хөлгийн дарга, түүний бүрэн эрх**

24.1. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай үнэмлэх, гэрчилгээ бүхий нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилно.



24.2. Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдлыг хангах, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор багийн гишүүд болон зорчигчид шаардлага тавьж, биелэлтийг хангуулах бөгөөд нислэгийн үйл ажиллагаатай холбоотой эцсийн шийдвэрийг гаргана.

24.3. Агаарын хөлгийн дарга иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэрийг дараах онцгой нөхцөлд гаргах эрхтэй:

24.3.1. хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул тулгарсан бол;

24.3.2. иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг мөрдөх нь тухайн онцгой нөхцөлийг хүндрүүлэхээр бол.

24.4. нислэгийн аюулгүй байдалд илт аюул тулгарсан тохиолдолд агаарын хөлөг болон түүний бүхээгт байгаа хүмүүсийн амь насыг аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргах;

24.5. Гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

### **25 дугаар зүйл. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа**

25.1 “Ерөнхий зориулалтын нисэх” гэдэгт арилжааны агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад агаарын хөлгийн үйл ажиллагааг ойлгоно.

25.2. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа нь агаарын хөлгийн овор жингээс үл хамаарч, тусгай зориулалтын нисэх, чөлөөт нисэх, нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

25.2.1. Тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд дараах үйл ажиллагаа хамаарна:

25.2.1.1. Хөдөө аж ахуйн болон аж ахуйн бусад агаарын хөлгийн үйл ажиллагаа;

25.2.1.2. Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх.

25.2.2. Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд шүхэр, агаарын бөмбөлөг, хүнгүй, хэт хөнгөн, хөнгөн агаарын хөлгөөр зорчигчийг зардал хуваах хэлбэрээр тээвэрлэх үйл ажиллагаа хамаарна.

25.2.3. Өөрийн эзэмшлийн агаарын хөлгөөр нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч дараах шаардлагыг хангасан байна:

25.2.3.1. нислэгт тэнцэх чадварын шаардлага хангасан агаарын хөлөгтэй байх;

25.2.3.2. хүчин төгөлдөр үнэмлэх, гэрчилгээ эзэмшигч нислэгийн ажилтантай байх;

25.2.3.3. үйл ажиллагаандаа тохирсон заавар, журамтай байх.

25.3. Нисэх клуб болон хувийн нислэгийн үйл ажиллагааг зардал хуваах хэлбэрээр гүйцэтгэж болно.

25.4. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд энэ хууль болон иргэний нисэхийн дүрмээс гадуур хориг, хязгаарлалт тогтоохыг хориглоно.

25.5. Хувийн нислэгийн үйл ажиллагааны нислэгийн аюулгүй байдлыг агаарын хөлөг эзэмшигч хариуцна.

25.6. Нислэгийн үйл ажиллагааг холбогдох иргэний нисэхийн дүрмээр зохицуулна.

## **26 дугаар зүйл. Нислэгийн үеийн дэг журам**

26.1. Багийн гишүүдээс бусад агаарын хөлөгт зорчиж байгаа этгээдийг . “зорчигч” гэнэ.

26.2. Зорчигч агаарын хөлгийн багийн гишүүдээс өгсөн зааварчилгааг нислэгийн туршид дагаж мөрдөх үүрэгтэй.

26.3. Багийн гишүүн нислэгийн үед аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авна.

26.4. Энэ хуулийн 27.2-д заасан шаардлагыг биелүүлээгүй, 27.3-т заасан дэг журам зөрчсөн зорчигчийн үйлдэлд албадлагын арга хэмжээ авах журмыг Сайд, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

## **27 дугаар зүйл. Нислэгийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

27.1. Нислэгийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

27.1.1. Бүртгэлгүй, эсхүл нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлгөөр нислэг үйлдэх, эсхүл нислэг үйлдэх эрхгүй этгээд гүйцэтгэх;

27.1.2. Агаарын хөлөгт гарал үүсэл тодорхойгүй, үйлдвэрлэгчийн техникийн тодорхойлолтод нийцээгүй эд анги ашиглах;

27.1.3. Иргэний нисэхийн дүрэм, үнэмлэх гэрчилгээний эрх, хязгаарлалтыг зөрчин нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх;

27.1.4. Агаарын хөлөгтэй холбоотой ажил, үйлчилгээнд нислэгийн ажилтны үнэмлэх, гэрчилгээгүй этгээдийг ажиллуулах, гэрчилгээгээр олгосон эрхээс хэтэрсэн ажил үүрэг гүйцэтгүүлэх;

27.1.5. Нисэх багийн гишүүдээс бусад этгээд нислэгийн үед агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нисэх багийн бүхээгт нэвтрэх.

27.2. “Нисэх баг” гэж нислэгийн хугацаанд агаарын хөлөгт нисгэгч, нисэх-инженерийн үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг ойлгоно.

## **28 дугаар зүйл. Аюул тулгарсан агаарын хөлөг**

28.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт аюул тулгарсан агаарын хөлгийн талаар зохих журмын дагуу холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

28.2. Чикагогийн конвенцын 19 дүгээр зүйлд тодорхойлсон аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг тухайн агаарын хөлгийг эзэмшигч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллага нь Монгол Улсын онцгой комисстой хамтран гүйцэтгэнэ.

28.3. Нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд аюул тулгарсан агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эмнэлгийн болон бусад зайлшгүй шаардлагатай тусламж үзүүлэх үүрэгтэй.

## **29 дүгээр зүйл. Агаарын тээвэрлэгчийн даатгал**

29.1. Агаарын тээвэрлэгч зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учрах хохирлыг барагдуулах зорилготой хариуцлагын даатгалтай байна.

29.2. Агаарын тээвэрлэгч албан үүргээ гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн багийн гишүүдийн амь нас, эрүүл мэндийг заавал даатгуулна.

29.3. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг гуравдагч этгээдэд учрах хохирлыг хариуцах баталгаа бүхий даатгалтай байна.

29.4. Агаарын тээврийн үйл ажиллагаанд зорчигч, гуравдагч этгээд амь насаа алдсан, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирсон, ачаа тээш, шуудан гэмтэж, алдагдсан тохиолдолд Монреалийн конвенцын заалтыг баримтлан агаарын тээвэрлэгч нөхөн төлбөр олгоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ. АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

### ***30 дугаар зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага***

30.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээг иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн төрийн өмчит хуулийн этгээд /цаашид агаарын навигацийн үйлчилгээний байгууллага гэх/ Монгол Улсын нэрийн өмнөөс үзүүлнэ.

30.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний менежмент, холбоо, навигаци, ажиглалт, нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уур болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах үйлчилгээнүүд, тэдгээрийн кибер аюулгүйн хамгаалалтыг багтаасан цогц үйл ажиллагааг нисэхийн аюулгүй байдлыг хангасан түвшинд хэрэгжүүлнэ.

30.3. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь 30.2-т заасан цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх чадамж бүхий хүний нөөцтэй байна.

### ***31 дүгээр зүйл. Нислэгийн хөдөлгөөний зохицуулалт***

31.1. Агаарын хөлөг нь Монгол Улсын агаарын зайг тогтоосон агаарын хаалгаар нэвтрэх, нислэг үйлдэнэ.

31.2. Агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг нь улсын хил нэвтрэх зөвшөөрлийг нислэгийн хөдөлгөөний удирдагчаас авна.

31.3. Агаарын зайн ангилал, бүтэц, зохион байгуулалт, агаарын хөлгийн хоорондын аюулгүйн зайчлал нь олон улсын иргэний нисэхийн стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцсэн байна.

31.4. Нислэгийн хөдөлгөөний хяналттай агаарын зай нь нисэхийн аюулгүй байдал, олон улсын иргэний нисэхийн стандарт, зөвлөмжийн шаардлагад нийцсэн агаарын навигацийн байгууламжаар тоноглогдсон байна.

31.5. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь нислэгийн хөдөлгөөнийг аюулгүй, үр ашигтай удирдан, зохион байгуулахад чиглэсэн Нислэгийн хөдөлгөөний менежментийг хэрэгжүүлнэ.

### ***32 дугаар зүйл. Агаарын навигацийн үйл ажиллагааны санхүүжилт***

32.1 Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь агаарын зам, нисэх буудлуудыг Конвенцын хавсралтуудын шаардлагыг хангасан агаарын навигацийн үйлчилгээ, агаарын навигацийн тоног төхөөрөмж, байгууламжаар хангахад тусгайлан зориулах агаарын навигацийн үйлчилгээний хураамжаас санхүүжих бөгөөд ашгийн бус байна.

32.2. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж нь агаарын навигацийн үйлчилгээг аюулгүй, тасралтгүй үзүүлэх, олон улсын иргэний нисэхийн дүрэм, стандартын суурь түвшинг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн сайд болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн сайд үйл ажиллагаа хэвийн явагдах хэмжээнд төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ. АЭРОДРОМ, НИСЭХ БУУДАЛ**

### **33 дугаар зүйл. Аэродром**

33.1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд иргэний нисэхийн дүрмийн дагуу аэродром байгуулна.

33.2. Агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

33.3. Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд нийтэд үйлчлэхээр зарлагдсан аэродром нь нислэгийн аюулгүй байдлыг хангах бодит шаардлагаас бусад үед агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзахыг хориглоно.

### **34 дүгээр зүйл. Нисэх буудал**

34.1. Нисэх буудал нь аэродромын гэрчилгээ бүхий байна.

34.2. Нисэх буудал нь олон улсын болон орон нутгийн нислэгт нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалт, аэродром, нисэхийн хангамж, газрын үйлчилгээ болон бусад нисэхийн ба нисэхийн бус үйлчилгээ үзүүлж болно.

34.3. Аэродромын гэрчилгээ эзэмшигч нь нисэх буудлыг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөөг хүрээлэн буй орчинд ээлтэй байхаар төлөвлөх бөгөөд тухайн хот, аймаг, сумын орон нутгийн байгууллагатай зөвшилцөнө.

### **35 дугаар зүйл. Аэродромын аюулгүйн бүс**

35.1. Аэродром орчмын аюулгүйн бүсийг иргэний нисэхийн дүрэм, стандартад заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

35.2. Аэродром орчмын аюулгүйн бүсэд нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх жагсаалт, барилга байгууламжийн өндрийн хязгаарлалтыг иргэний нисэхийн стандартын дагуу зохицуулна.

### **36 дугаар зүйл. Дохио, тэмдэг**

36.1. Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч аэродром, түүний орчинд агаарын хөлөг хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан аэродромын дохио, тэмдгийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу байрлуулна.

36.2. Аэродромын аюулгүйн бүсэд барилга байгууламж өмчлөгч буюу эзэмшигч агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор уг барилга байгууламж дээр аюулгүй байдлын дохио, тэмдэгийг иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу байрлуулна.

36.3. Аэродромын аюулгүйн бүсэд агаарын хөлгийн чиг баримжаа тогтооход зориулсан аюулгүй байдлын дохио, тэмдэгтэй ижил төстэй зүйл байрлуулахыг хориглоно.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ. НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ**

### **37 дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалт**

37.1. Иргэний нисэхийг хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахыг “Нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэнэ.

37.2. Хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг илрүүлэхэд чиглэсэн техникийн болон бусад арга хэрэгслээр хийх үзлэгийг “аюулгүйн үзлэг” гэнэ.

37.3. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагууд иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах, таслан зогсооход шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлнэ.

### **38 дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ**

38.1. Аюулгүйн хамгаалалттай аэродром болон аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламжийн аюулгүйн хамгаалалтыг иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн байгууллага гүйцэтгэнэ.

38.2. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага нь агаарын хөлгийн багийн гишүүн, зорчигч, тээш, ачаа, шуудан, нислэгийн хоол хүнс болон хангамжийн эд зүйлд аюулгүйн үзлэг хийнэ.

38.3. Өндөржүүлсэн хамгаалалттай бүсэд болон түүнд нэвтрэхээс өмнө хүн, тэдгээрийн авч яваа эд зүйлс болон тээврийн хэрэгсэлд аюулгүйн үзлэгийн ажилтан үзлэг, шалгалт хийнэ.

38.4. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага нь агаарын хөлгийн багийн гишүүн, зорчигч, тээш, ачаа, агаарын хөлөг, аэродром болон агаарын навигацийн байгууламжид шалгалт хийж, эд зүйлийг хураах эсхүл саатуулна.

38.5. Зорчигч аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан тохиолдолд агаарын хөлгөөр тээвэрлэх гэрээг тухайн агаарын тээвэрлэгч цуцалж болно.

38.6. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль, тогтоомжийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор саатуулна.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ**

### **39 дүгээр зүйл. Иргэний нисэхийн хяналт**

39.1. Иргэний нисэхийн хяналтыг холбогдох хууль тогтоомж, иргэний нисэхийн хяналтын дүрмийн хүрээнд дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

- 39.2.1. Агаарын хөлгийг зохион бүтээх, үйлдвэрлэх үйл ажиллагаа;
- 39.2.2. Агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч (Агаарын тээврийн үйл ажиллагаа, Тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа, Нисэх клуб, Хувийн нисэхийн үйл ажиллагаа, Хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа)-ийн үйл ажиллагаа;
- 39.2.3. Аэродром, нисэх буудлын үйл ажиллагаа;
- 39.2.4. Агаарын навигацийн үйлчилгээ;
- 39.2.5. Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаа;
- 39.2.6. Агаарын хөлөг болон түүний бүрэлдэхүүн хэсгийн техник үйлчилгээ;
- 39.2.7. Нисэхийн сургалтын байгууллага;
- 39.2.8. Нисэхийн хангамжийн үйл ажиллагаа;
- 39.2.9. Зохицуулалттай агаарын ачааны байгууллагын үйл ажиллагаа;
- 39.2.10. Иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон үнэмлэх, зэрэглэл эзэмшигч, түүний ур чадварын хадгалалт;
- 39.2.11. Бусад.

#### **40 дүгээр зүйл. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч**

40.1. Энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан хяналтыг Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын улсын байцаагч /цаашид “Байцаагч” гэх/ хэрэгжүүлнэ.

40.2. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь тухайн хяналтын чиглэлээр мэргэшсэн, холбогдох хууль тогтоомж, иргэний нисэхийн олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэг, дадлага туршлага, ур чадвартай байна.

40.3. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагчид тавигдах шаардлага хангасан, байцаагчийг сонгон шалгаруулах, мэргэшүүлэх, нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийн хөгжлийг тодорхойлсон хөтөлбөртэй байна.

40.4. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, шаардлага, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцна.

#### **41 дүгээр зүйл. Байцаагчийн бүрэн эрх**

41.1. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхтэй:

41.1.1. Агаарын хөлөг; иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллага; түүний агаарын хөлгийг агуулах, техник үйлчилгээний байгууламж; агаарын хөлгийн зогсоол; аэродром, нисэх буудлын байгууламж; агаарын навигацийн байгууламж; шатахуун хадгалах, түгээх байгууламж; ачааны байгууламж; нисэхийн сургалтын байгууллага; нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага; баримт бичиг; мэдээлэл; зэрэг иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой объектод шалгалт хийх зорилгоор саадгүй нэвтрэх.

41.1.2. Иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдол бүхий хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, дуу, дүрс, бичлэг бусад баримт бичгийг холбогдох иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах;

41.1.3. Агаарын хөлөг нислэгт тэнцэх чадваргүй; нисэх баг нислэг үйлдэхэд эрүүл мэнд болон сэтгэл зүйн хувьд чадамжгүй; нисэхийн үйл ажиллагаа нь хувь хүн эсхүл эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй; эсхүл дарга зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн нөхцөл арилах хүртэл агаарын хөлгийг саатуулах;

41.1.4. Хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох этгээдийн баримт бичгийг хураах;

41.1.5. Шаардлагатай дуу, дүрсний бичлэг хийх, баримтжуулах үйл ажиллагааг зохион байгуулах.

41.1.6. Нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын сорилт хийх.

41.1.7. Хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **42 дугаар зүйл. Байцаагчийн ажиллах нөхцөл, баталгаа**

42.1. Байцаагчийн цалин хөлсийг иргэний нисэхийн салбарын адилтгах албан тушаалын дундаж цалингаас багагүйгээр тогтоох ба шаардлагатай тохиолдолд нэмэгдэл хөлс олгож болно.

42.2. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь түүний эрхийн хүрээг тодорхой заасан үнэмлэхтэй байна.

42.3. Иргэний нисэхийн аюулгүйн хяналтын байцаагч нь дүрэмт хувцас, тээврийн хэрэгсэл болон шаардлагатай бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ**

### ***43 дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа***

43.1. Агаарын хөлөг өмчлөгч эзэмшигч, нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, агаарын хөлгийн дарга, нисэх багийн гишүүд, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанд нэн даруй, боломжит хэлбэрээр өгнө.

43.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба ослын мэдээллийг хүлээн авмагц шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлнэ.

43.3. Осол, зөрчилд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой эд мөрийн баримтыг агаарын хөлөг өмчлөгч эзэмшигч болон холбогдох бусад этгээд шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж, хамгаална.

43.4. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр агаарын хөлгийн осол, зөрчил гарсан үед иргэн, нутгийн захиргааны байгууллага, онцгой байдлын газар, цагдаа болон зэвсэгт хүчний анги салбарууд Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанд үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах туслалцааг цаг тухайд нь үзүүлэх үүрэгтэй.

### ***44 дүгээр зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны зарчим***

44.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилготой ба аливаа этгээдийн гэм бурууг тогтоохгүй.

44.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь хараат бус, бие даасан байна.

### ***45 дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба***

45.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Конвенцын Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба гүйцэтгэнэ.

45.3. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд байна.

45.4. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба энэ хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагаа гүйцэтгэхэд хүрэлцэхүйц хэмжээний төсөвтэй байна.

45.5. Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна осол, ноцтой зөрчилд өртсөн үед шинжлэн шалгах ажиллагааг олон улсын хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх ба Монгол Улсын нэрийн өмнөөс Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба оролцож болно.

45.6. Төрийн бусад байгууллага Конвенцын Хавсралт 13-ын зорилгоор агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхийг хориглоно.

45.7. Энэ хуулийн 45.6 дугаар зүйлд заасан ажиллагаа нь хууль хяналтын болон бусад байгууллага агаарын хөлгийн осол, зөрчлийг энэ хуульд зааснаас өөр зорилгоор шалгах ажиллагаанд хамаарахгүй.

45.8. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, түүний шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоон, тайлан гаргана.

45.9. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

45.10. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагчийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны болон иргэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.

45.11. Шинжлэн шалгах баг осол болсон газарт ажиллахад шаардлагатай хамгаалах хувцас хэрэгсэл, төхөөрөмж болон холбоо, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

#### **46 дугаар зүйл. Ерөнхий шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх**

46.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албыг Ерөнхий шинжлэн шалгагч удирдана.

46.2. Ерөнхий шинжлэн шалгагч шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн, холбогдох хууль, иргэний нисэхийн дүрэм, заавар, иргэний нисэхийн талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар зохих мэдлэгтэй, Монгол Улсын иргэн байна.

46.3. Ерөнхий шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

46.3.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ажилтан, шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;

46.3.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах багийн ахлагч болон гишүүдийг томилох;

46.3.3. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

46.3.4. Ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

46.3.5. Шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг батлах;

46.3.6. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;

46.3.7. Шинжлэн шалгах ажиллагаанд мөрдөх дотоод үйл ажиллагааны заавар, журмыг батлах.

#### **47 дугаар зүйл. Шинжлэн шалгагч, түүний бүрэн эрх**

47.1. Шинжлэн шалгагч нь агаарын тээврийн нисгэгчийн зэрэглэлтэй нисгэгч, агаарын хөлгийн инженер эсхүл шинжлэн шалгах болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.

47.2. Шинжлэн шалгагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

47.2.1. Албан үүргээ гүйцэтгэхдээ агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой барилга байгууламжид ямар ч цагт саадгүй нэвтрэх, холбогдох эд мөрийн баримтыг гаргуулах;

47.2.2. Шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох хувь хүн, хуулийн этгээдээс шаардан авах;

47.2.3. Ерөнхий шинжлэн шалгагчаас олгосон бусад эрх.

#### **48 дугаар зүйл. Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх**

48.1. Шинжлэн шалгах багийн ахлагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



- 48.1.1. Агаарын хөлгийн осол, зөрчил болсон газарт ямар ч цагт саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст хяналтаа тогтоох;
- 48.1.2. Нислэгийн бичлэгийн төхөөрөмж, тухайн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой агаарын навигацийн үйлчилгээний бичлэгүүд зэрэг бусад нотлох баримтыг өөрийн хяналтад авах;
- 48.1.3. Шинжлэн шалгах ажиллагааг цаг алдалгүй эхлүүлэх зорилгоор холбогдох эд мөрийн баримт, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн үлдэгдлийг өөрийн хяналтад авах;
- 48.1.4. Шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйл үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;
- 48.1.5. Ослын газрыг хамгаалалтад авах зорилгоор эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
- 48.1.6. Шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;
- 48.1.7. Шинжлэн шалгах ажиллагааны явцыг ерөнхий шинжлэн шалгагчид танилцуулах, ослын боломжит шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан Аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажиллагааг зохион байгуулах;
- 48.1.8. Ослын газрын хамгаалалтыг буулгах, шинжлэн шалгах ажиллагаанд цаашид шаардлагагүй болсон агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;
- 48.1.9. Шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төслийг гаргах;
- 48.1.10. Хууль тогтоомжоор олгосон бусад бүрэн эрх.

#### **49 дүгээр зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан**

49.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба эцсийн тайланг гаргахаас өмнө тухайн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон эрх бүхий байгууллагуудаас санал авахаар тайлангийн төслийг хүргүүлнэ.

49.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба агаарын хөлгийн осол, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны тайланг боломжит богино хугацаанд гаргана.

49.3. Агаарын хөлгийн осол, зөрчлийн шинжлэн шалгах ажиллагааны тайлан болон аюулгүй байдлын зөвлөмжийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны хариуцлага хүлээлгэх, хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй.

#### **50 дугаар зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж**

50.1. Шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа болон төрөл бүрийн эх үүсвэрийг үндэслэн агаарын хөлгийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий байгууллагаас гаргасан саналыг “Аюулгүй байдлын зөвлөмж” гэнэ.

50.2. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

50.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг агаарын хөлөг үйлдвэрлэгч, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагад, шаардлагатай бол Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлнэ.

50.4. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн 90 хоногийн дотор эргэж мэдэгдэнэ. Хэрэгжүүлэх боломжгүй бол үндэслэл бүхий тайлбараа гаргаж хүргүүлнэ.

50.5. Энэ хуулийн 50.4-т заасан этгээд аюулгүй байдлын зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа бол тайлбарыг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албанд нэн даруй хүргүүлнэ.

50.6. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд зөвлөмжийн дагуу хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 90 хоногийн дотор эргэж мэдэгдэх үүрэгтэй.

#### **51 дүгээр зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх**

51.1. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайлан гарсны дараа тайлангийн дүгнэлтийг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн бол Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба шинжлэн шалгах ажиллагааг сэргээх үүрэгтэй.

### **АРАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ**

#### **52 дугаар зүйл. Үйл ажиллагааны санхүүжилт**

52.1. Иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй хамгаалалтын хяналт, зохицуулалт, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагаа улсын төсвөөс санхүүжнэ.

52.2. Сайд төсвийн зарлагын хэмнэлт, иргэний нисэхийн үйлчилгээний нэмэлт орлогыг иргэний нисэхийн салбарыг бэхжүүлэх арга хэмжээнд зарцуулна.

#### **53 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

53.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

53.2. Энэ хуулийг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **54 дүгээр зүйл. Иргэний нисэхэд ашиглах хэл**

54.1. Иргэний нисэхэд ашиглах техник, технологийн баримт бичгийг Монгол, Англи хэл дээр хэрэглэж болно.

54.2. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг Англи хэл дээр үзүүлж болно.

#### **55 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

55.1. Энэ хуулийг 2022 оны .... дүгээр сарын ....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---